АЖЛЫН БАЙРНЫ ЗАР · 2024 оны 4-р сарын 2

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР: ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн жинхэнэ албан хаагчийг нэгж прокурорын газруудын "Тамгын хэлтсийн дарга"-ын албан тушаалд холбогдох материалаа ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- Төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал

- Хүсэлт
- Төрийн албан хаагчийн анкет;
- Гурван үеийн намтар;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшин тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа /e-mongolia–аас татан авах/;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/.
- Тухайн орон тоонд шилжин ажиллахыг хүссэн өргөдөл.

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 17:00 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: **s.siilegmaa@prosecutor.mn** цахим шуудангаар
- Холбоо барих утас: 51-260855, 88019466 /ажлын цагаар/

Шилжүүлэх, сэлгэн авах ажлын байрны жагсаалт

Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаалын нэр	Орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага			
				Ангилал	Зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
Аймаг, дүүргийн прокурорын газар	Тамгын хэлтэс	Тамгын хэлтсийн дарга	3	Эрхэлсэн түшмэл	АА-5	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	-Эрх зүйч -төрийн болон бизнесийн удирдлага	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1512